БИЗКОН АУДИТ

БИЗКОН АУДИТ КОМПАНИЙН ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ САЛБАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2022/210/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Бизкон аудит ХХК-ийн

Ахлах аудитор Ч.Мөнхбаяр

Утас: 99996784 Цахим хаяг:mm.bayar0711@gmail.com

Аудитор: Л.Пунсал-орлом

Утас: 88908680 Цахим хаяг: punsaa73@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.Аудитын санал дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....10
3. Аудитын тайлан....10
3.1 Ерөнхий зүйл....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....11
3.4 Материаллаг байдал....12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....14
3.8 Аудитын гол асуудал....14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....15
4. Аудитын илрүүлэлт....15
4.1 Залруулсан алдаа....15
4.2 Төлбөрийн акт....15
4.3 Албан шаардлага....15
4.4 Зөвлөмж....15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....17

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| МУ | Монгол улс |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

67120. Хөвсгөл аймаг. Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас,факс: 70-38 37-93
Э-майл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.02.23 № 01/116
танай ____________ -ны № ____________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
АРВАН ТАВДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ө.СЭЛЭНГЭ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **66,680,425.54** | **61,261,794.70** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | 500,000.00 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 500,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 66,180,425.54 | 61,261,794.70 |
| **354** | **Хангамжийн материал** | 66,180,425.54 | 61,261,794.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 00.00 | 25,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 285,000.00 | 290,900.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 50,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 3,653,950.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,983,124.90 | 1,803,480.20 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 61,912,300.64 | 55,438,464.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **929,235,029.27** | **1,015,101,179.62** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 929,235,029.27 | 1,015,101,179.62 |
| **392** | **Биет хөрөнгө** | 928,319,050.18 | 907,279,950.61 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 826,673,857.00 | 826,673,857.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -9,110,799.90 | -25,291,948.74 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 39,501,405.30 | 48,732,614.38 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -5,028,176.97 | -14,259,724.82 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,506,376.92 | 30,816,376.92 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -1,473,936.37 | -4,224,574.21 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 53,281,520.20 | |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -3,031,196.00 | 53,281,520.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 915,979.09 | 107,821,229.01 |
| 39301 | Програм хангамж | 1,155,000.00 | 1,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -239,020.91 | -483,770.99 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 107,150,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **995,915,454.81** | **1,076,362,974.32** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **00.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **995,915,454.81** | **1,076,362,974.31** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 995,915,454.81 | 1,076,362,974.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 00.00 | 107,150,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 00.00 | 107,150,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 995,915,454.81 | 969,212,974.31 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 995,915,454.81 | 995,915,454.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -26,702,480.50 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **995,915,454.81** | **1,076,362,974.32** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,600,233,808.62** | **451,863,079.08** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,539,195,008.62** | **12,127,709.08** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,094,673,808.62 | 12,127,709.08 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 444,521,200.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 444,521,200.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **61,038,800.00** | **57,014,470.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 382,720,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 500,000.00 | 2,109,870.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 1,261,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 848,070.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 60,538,800.00 | 54,904,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,538,800.00 | 54,904,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **604,745,803.81** | **478,001,559.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **604,745,803.81** | **478,001,559.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 577,082,693.58 | 454,065,652.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 282,738,455.73 | 299,329,936.00 |
| 210101 | Үндсэн цалин | 215,451,582.73 | 216,506,758.69 |
| 210102 | Нэмэгдэл | 43,428,751.00 | 58,876,977.31 |
| 210104 | Урамшуулал | 23,858,122.00 | 23,946,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,184,670.50 | 39,269,149.08 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,826,939.82 | 27,488,250.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,796,984.87 | 2,925,677.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,373,942.48 | 2,414,424.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 564,500.43 | 588,300.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,622,302.90 | 5,852,495.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,660,650.54 | 48,360,182.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,993,712.54 | 2,873,248.62 |
| 210302 | Түлш, халаалт | 47,148,142.00 | 40,112,613.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,518,796.00 | 5,374,320.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,462,730.00 | 3,550,920.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 736,400.00 | 333,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,024,700.00 | 300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 225,900.00 | 234,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,306,000.00 | 1,455,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,169,730.00 | 1,227,820.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 24,318,669.10 | 11,413,434.60 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,390,122.00 | 75,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,928,547.10 | 11,337,934.60 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,441,950.00 | 1,441,866.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 543,500.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,898,450.00 | 1,441,866.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,793,900.00 | 1,444,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,493,900.00 | 724,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 720,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 154,481,667.71 | 49,255,664.87 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 130,931,906.22 | 12,516,106.14 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,562,600.00 | 2,914,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,987,161.49 | 33,825,058.73 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 27,663,110.23 | 23,935,906.71 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 378,149.46 | 1,448,601.68 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 378,149.46 | 1,448,601.68 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 27,084,960.77 | 22,487,305.03 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,084,960.77 | 22,487,305.03 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **995,488,004.81** | **-26,138,480.50** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 00.00 | 00.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 564,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 564,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -564,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **995,488,004.81** | **-26,702,480.50** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 995,488,004.81 | 995,488,004.81 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.00** | **995,915,454.81** | 995,915,454.81 |
| **2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **00.00** | **995,915,454.81** | 995,915,454.81 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **995,915,454.81** | 995,915,454.81 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 107,150,000.00 | 00.00 | 107,150,000.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | -26,702,480.50 | -26,702,480.50 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **107,150,000.00** | **969,212,974.31** | 1,076,362,974.31 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **505,560,000.00** | **440,235,370.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **444,521,200.00** | **382,720,900.00** |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 444,521,200.00 | 382,720,900.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 444,521,200.00 | 382,720,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **61,038,800.00** | **57,514,470.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 500,000.00 | 2,609,870.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 1,261,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 1,348,070.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 60,538,800.00 | 54,904,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,538,800.00 | 54,904,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **487,017,400.00** | **436,172,370.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **487,017,400.00** | **436,172,370.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **458,854,289.77** | **412,236,463.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 282,738,455.73 | 300,639,943.10 |
| 210101 | Үндсэн цалин | 215,451,582.73 | 217,816,765.79 |
| 210102 | Нэмэгдэл | 43,428,751.00 | 58,876,977.31 |
| 210104 | Урамшуулал | 23,858,122.00 | 23,946,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,184,670.50 | 37,962,641.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,826,939.82 | 26,181,743.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,796,984.87 | 2,925,677.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,373,942.48 | 2,414,424.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 564,500.43 | 588,300.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,622,302.90 | 5,852,495.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 55,660,650.54 | 48,360,182.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,993,712.54 | 2,873,248.62 |
| 210302 | Түлш, халаалт | 47,148,142.00 | 40,112,613.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,518,796.00 | 5,374,320.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,655,810.00 | 5,828,920.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 419,500.00 | 367,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,024,700.00 | 350,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 225,900.00 | 234,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 178,530.00 | 220,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,306,000.00 | 1,455,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,501,180.00 | 3,200,520.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,042,350.00 | 8,999,459.90 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,665,122.00 | 75,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,904,228.00 | 8,923,959.90 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,473,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,022,400.00 | 5,095,816.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 842,400.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 180,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 500,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 5,095,816.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,873,900.00 | 1,444,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 14,573,900.00 | 724,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 720,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,676,053.00 | 3,905,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 161,053.00 | 893,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,515,000.00 | 3,012,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,163,110.23** | **23,935,906.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 878,149.46 | 1,448,601.68 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 878,149.46 | 1,448,601.68 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 27,084,960.77 | 22,487,305.03 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,084,960.77 | 22,487,305.03 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **18,542,600.00** | **4,063,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **18,542,600.00** | **4,063,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **18,542,600.00** | **4,063,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 18,542,600.00 | 4,063,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,542,600.00 | 4,063,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-18,542,600.00** | **-4,063,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** |
|---|---|---|

| ангилал | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 437,625,500.00 | 413,689,663.29 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 437,625,500.00 | 413,689,663.29 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 437,625,500.00 | 413,689,663.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 307,907,500.00 | 300,639,943.10 |
| 210101 | Үндсэн цалин | 220,469,100.00 | 217,816,765.79 |
| 210102 | Нэмэгдэл | 63,492,200.00 | 58,876,977.31 |
| 210104 | Урамшуулал | 23,946,200.00 | 23,946,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,567,400.00 | 37,962,641.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,251,200.00 | 26,181,743.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,079,100.00 | 2,925,677.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,463,200.00 | 2,414,424.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 615,800.00 | 588,300.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,158,100.00 | 5,852,495.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,817,600.00 | 48,360,182.32 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,200,000.00 | 2,873,248.62 |
| 210302 | Түлш, халаалт | 40,117,600.00 | 40,112,613.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,500,000.00 | 5,374,320.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,294,900.00 | 3,962,120.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 225,900.00 | 112,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 300,000.00 | 300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 225,900.00 | 234,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 188,300.00 | 220,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,150,000.00 | 874,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,204,800.00 | 2,220,520.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 15,950,100.00 | 8,999,459.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 75,500.00 | 75,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,874,600.00 | 8,923,959.90 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,840,000.00 | 9,158,816.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 753,000.00 | 753,000.00 |
| 210602 | Тавилга | 5,000,000.00 | 3,310,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,087,000.00 | 5,095,816.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,671,200.00 | 1,394,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 951,200.00 | 674,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3576800.00 | 3212000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 564,800.00 | 200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,012,000.00 | 3,012,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 437,625,500.00 | 413,689,663.29 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 382,720,900.00 | 360,233,664.97 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 54,904,600.00 | 53,455,998.32 |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 00.00 | 00.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 00.00 | 00.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 27.00 | 27.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,609,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,609,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,609,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,866,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 255,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 581,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 980,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 50,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 693000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 693,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2609800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,609,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,261,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,348,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зардал, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн гэрээт аудитор Л.Пунсал-Орлом, туслах аудитор Б.Түмэндэмбэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Бизкон Аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Мөнхбаяр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулдаг Мөрөн сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хөвсгөл аймгийн засаг даргын 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тус байгууллага нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэг нь 2020 оны Б/29 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Тайлант онд 8 ажил гүйцэтгэхээр төлөвлөгөө батлуулан ажиллаж дотоод хяналтын ажлын тайлан бичсэн боловч хангалтгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 611.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 80.5 сая төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 00 | 00 | 00 |
| Авлага | 0.5 | 00 | -0.5 |
| Урьдчилгаа | 00 | 00 | 00 |
| Бараа материал | 66.2 | 61.3 | -4.9 |
| Үндсэн хөрөнгө | 929.2 | 1,015.1 | 85.9 |
| **Нийт хөрөнгө** | 995.9 | 1,076.4 | 80.5 |
| Өр төлбөр | 00 | 00 | 00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 995.9 | 1,076.4 | 80.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 995.9 | 1,076.4 | 80.5 |

Тайлант онд БШУЯ-аас үнэ төлбөргүйгээр 6 нэр төрлийн 9.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 18 дугаар тогтоолоор 107.1 сая төгрөгийн газар эзэмших эрх, төсвийн хөрөнгөөр 3 нэр төрлийн 4.1 сая төгрөгийн хөрөнгө, нийт 120.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Мөн 1 нэр төрлийн 0.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагын тушаал, шийдвэрийг үндэслэн акталж устгасан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 511.1 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 8.9 сая төгрөгөөр бууруулж 502.2 сая төгрөгөөр 2021 оны төсвийг баталсан байна. Тус байгууллагын төсөвт Мөрөн сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 24-ний 02 тоот тогтоолоор төсвийг 33.0 сая төгрөгөөр хасах зохицуулалт, Хөвсгөл аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 тоот захирамжаар 31.6 сая төгрөгөөр төсвийг хасах зохицуулалт, нийт 64.6 сая төгрөгөөр төсвийг хасах зохицуулалтыг хийж, санхүүжүүлэх эх үүсвэрийг 437.6 сая төгрөг болгосон байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн 4 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 437.6 сая төгрөгийн төсөв батлалсан ба 382.7 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 54.9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд улсын төсвөөс 382.7 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 54.9 сая төгрөг, нийт 437.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 413.7 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 23.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 413.7 сая төгрөг буюу 94.5 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардал 62.9 хувийн, норматив зардал 56.4 хувийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 83.4 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна. Хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулбал:

***Хүснэгт2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /үндсэн/ /сая төгрөг/***

| Хөтөлбөр, арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| ***71801*** | **Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр** | ***437.6*** | ***413.7*** | ***23.9*** | ***94.5*** |
| 80109 | ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардал | 54.9 | 53.5 | 1.4 | *97.4* |
| 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 15.9 | 8.9 | 7.0 | *56.2* |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 207.7 | 200.0 | 7.7 | *96.3* |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 159.1 | 151.3 | 7.8 | *95.1* |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны хүрээнд 1 хөтөлбөрийн зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1.3 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн

үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.3 сая төгрөг, нийт 2.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж дээд шатны эрх бүхий байгууллагын шийдвэрээр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, БҮТЭЗ-ийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, хог хаягдал, хортон мэрэгчдийг устгах зардлуудад 2.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу цахим засаглал үндэсний хөтөлбөрийн хүрээнд биет болон биет бус хөрөнгийг бүртгэлд тусгасан эсэх, зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа эсэх асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар төлөвлөгөөнд тусгасны дагуу шалгахад асуудалтай зүйл илэрсэнгүй.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Тайлант оны дундуур буцааж татсан санхүүжилтийн дүн 11.3 сая төгрөгийг орлого бууруулж бүртгэсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан. Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

МУ-ын ерөнхий аудиторын 2021 оны 10 дугаар сарын 08-н ы өдрийн А/92 тоот тушаалаар баталсан аргачлалын дагуу шалгахад тайлант онд шилэн дансанд байршуулах мэдээнээс "5 сая төгрөгөөс дээш нийт худалдан авалтын " мэдээнээс хугацаа хоцорч мэдээлсэн 1 мэдээ, " 5 сая төгрөгөөс дээш нийт зарлагын гүйлгээ" мэдээнээс нийт 10.0 сая төгрөгийн 2 мэдээ мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд 10.0 сая төгрөгийн 3 мэдээ хугацаа хоцорч байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх дүрмийн сангийн хэмжээ 19.2 сая төгрөг, санхүүгийн тайлан дахь төрийн болон орон нутгийн эзэмшлийн өмчийн дүн 107.1 сая төгрөг байгаа ба 87.9 сая төгрөгөөр зөрүүтэй

мөн эрхлэгч солигдсоныг бүртгүүлээгүй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна. Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар онцгойлон үзэх ноцтой асуудал байхгүй байна.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 118.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс илэрснээс 107.1 сая төгрөгийн алдааг залруулж, 11.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын дараах алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тайлант онд бүртгэлд тусгасан 107.1 сая төгрөгийн газар эзэмших эрхийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэснийг залруулав.

4.1 Залруулсан алдаа

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдсан алдаа байхгүй байна.

4.2 Төлбөрийн акт

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Зардалтай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд цалингийн зардлаас 1.3 сая төгрөгийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал руу зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчиж байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулж хэвших.

**2. Шилэн данстай холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансанд байршуулах мэдээнээс "5 сая төгрөгөөс дээш нийт худалдан авалтын" мэдээнээс хугацаа хоцорч мэдээлсэн 1 мэдээ, " 5 сая төгрөгөөс дээш нийт зарлагын гүйлгээ"-ний мэдээнээс нийт 10.0 сая төгрөгийн 2 мэдээ тус тус мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан хугацаанд шилэн дансанд мэдээллийг мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: /Э.БАТ-ЭРДЭНЭ/

Огноо:

АХЛАХ АУДИТОР /Г.ЭРДЭНЭЧИМЭГ/

Огноо:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН АХЛАХ АУДИТОР /Ч.МӨНХБАЯР/

Огноо:

БОЛОВСРУУЛСАН:

БИЗКОН АУДИТ ХХК-ЫН ГЭРЭЭТ АУДИТОР /Л.ПУНСАЛ-ОРЛОМ/

Огноо: 2022.02.21.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Хөвсгөл аймгийн Мөрөн сумын арван тавдугаар цэцэрлэг | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | **3** | 118,4 | 1 | 107,1 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 11.3 |